



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Цагдаагийн гудамж 78, 7 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171
Утас: (976-11) 35 02 54, 35 02 52,
Цахим шуудан: info@derma.gov.mn,
Цахим хуудас: www.derma.gov.mn

2026.04.01 № 01/136
танай _____-ны № _____-г

Түүхийн номд материал ирүүлэх тухай

ЭМС-ын 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Монгол улсад орчин цагийн арьс өнгөний салбар үүсэн байгуулагдсаны 100, АӨСҮТ-ийн 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай ЭМС-ын А/107 тоот тушаал батлагдаж, ойд зориулан тус салбарт харъяалагддаг төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-удтай хамтран түүхийн ном гаргахаар төлөвлөж байна.


Иймд түүхийн номд оруулах Арьс өнгө, арьс судлалын салбартай холбоотой их сургууль, эрүүл мэндийн байгууллага, эмнэлэг, алба, тасаг, хамт олон, хувь хүний түүх, дурсамжийг архивын материал, гэрэл зургийн хамт 2026 оны 05 сарын 16 -ны дотор ирүүлнэ үү.

100 жилийн түүхийг хамтдаа бүтээлцсэн, бүтээлцэж байгаа та бүхэнтэй хамтран ажиллахад таатай байна. Түүхийн номд тавигдах шаардлага, материал хүлээн авах алба, ажилтны утасны дугаар, цахим хаягийг ЭМС-ын тушаалын хамт хавсралтаар хүргүүлж байна.

ЗАХИРАЛ  Ц.УРАНЧИМЭГ



Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
2026 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн
04/136 тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт



Түүхийн номын материалд тавигдах шаардлага

1. Түүхийн эх монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу бичигдсэн байх
2. Гэрэл зураг нягтрал сайтай, хар болон өнгөт байж болно. Зургийг цахимаар ирүүлэхдээ JPG (гэрэл зургийн чанарын шаардлага хангасан) байдлаар ирүүлэх
3. Microsoft word программын Ariel font-оор, үсгийг 12 хэмжээтэй, мөр хоорондын зай single -ээр бичнэ.
4. Байгууллага, тасаг хамт олны түүх, ажилтнуудын дурсамж, гэрэл зургийн хамт нийт 1 - 4 нүүр байна.
5. Хувь хүний түүх, намтар, дурсамж 1-2 нүүр байна.
6. Эх сурвалж (ном зүй, архив, хувь хүний тэмдэглэл, яриа гэх мэт) -аа тодорхой бичнэ.
7. Материалыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлж болно.

Хаяг: АӨСҮТ-ийн Амбулатори, Сургалтын алба, Мэдээлэл технологийн алба

Утас: 99080434, 88091821, 94113221, 88333072

Цахим хаяг: guntsogzol@gmail.com,

lkhagvasurenmd@gmail.com,

Duluu1245@gmail.com, haltarglgherle@gmail.com



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Ой тэмдэглэх тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Арьс өнгөний алба үүсэж хөгжсөний 100 жил, Арьсны өвчин судлалын үндэсний төв байгуулагдсаны 80 жилийн ойг 2026 оны 9 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Түүхт ойг холбогдох хууль тогтоомж, батлагдсан төсвийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг Арьсны өвчин судлалын үндэсний төв (Ц.Уранчимэг), Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141260506